



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/79

Пионер толгой

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1, 2.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 10/04 тоот тогтоолын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хийгдэж, хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 2022-09 дугаар актаар хүлээн авсан Жаргалант хөндийн худгийн усан онгоцыг 1500000 /нэг сая таван зуун мянга/ төгрөг, 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 2022-03 тоот актаар хүлээн авсан Хогийн цэгийн хайсжуулалтын ажлыг 12800000 /Арван хоёр сая найман зуун мянга/ төгрөг, 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 2022/05 дугаар актаар хүлээн авсан Ус зөөврийн авто машиныг 34773000 /Гучин дөрвөн сая долоон зуун далан гурван мянга/ төгрөгийн хөрөнгө, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар актаар хүлээн авсан Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн багаж хэрэгсэл, нөөц бүрдүүлэлтийн ажлыг 5000000 /таван сая/ төгрөгөөр, Баяр наадмын зардлаас бэлдсэн Хурдан морь унагч хүүхдийн карт уншигчийг 242000 /хоёр зуун дөчин хоёр мянга/ төгрөгөөр, 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 15 дугаар бүхий актаар хүлээн авсан 1,4-р багийн төвийн тохижилтын ажлыг 15840000 /Арван таван сая найман зуун дөчин мянга/ төгрөгөөр, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 15 тоот актаар хүлээн авсан Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг 14750000 /Арван дөрвөн сая долоон зуун тавин мянга/ төгрөгөөр, 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01 тоот актаар хүлээн авсан Тоглоомын талбайн ажлыг 15000000 /Арван таван сая/ төгрөгөөр тус Засаг даргын Тамгын газрын дансанд бүртгэсүгэй..

2.Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хийгдэж, хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн БХАГБЗДТГ202212003 дугаар актаар хүлээн авсан Дотуур байны тохижилтын ажлыг 23866760 /Хорин гурван сая найман зуун жаран зургаан мянга долоон зуун жаран/ төгрөгөөр, 2022 оны 12

642201383

дугаар сарын 22-ны өдрийн 2022/12 тоот актаар хүлээн авсан Урлагийн заалны тохижилтын ажлыг 15000000 /Арван таван сая / төгрөгөөр сургуулийн хөрөнгийн бүртгэлд бүртгэсүгэй.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хийгдэж, хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2022-а10 дугаар актаар хүлээн авсан Гэрэлтүүлгийн ажлын 1643000 /нэг сая зургаан зуун дөчин гурван мянга/ төгрөгийн хөрөнгийг соёлын төвд, 2693000 /Хоёр сая зургаан зуун ерэн гурван мянга/ төгрөгийн хөрөнгийг Эрүүл мэндийн төвд, 6226000 /Зураан сая хоёр зуун хорин зургаан мянга/ төгрөгийн хөрөнгийг сургуульд, 1538000 /Нэг сая таван зуун гучин найман мянга/ төгрөгийн хөрөнгийг цэцэрлэгт, 7900000 /Долоон сая есөн зуун мянга/ төгрөгийг хөрөнгийг Засаг даргын тамгын газрын хөрөнгийн бүртгэлд бүртгэсүгэй .

4. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хийгдэж, хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаар актаар хүлээн авсан Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг 20350000 /Хорин сая гурван зуун тавин мянга/ төгрөг Эрүүл мэндийн төвийн хөрөнгийн бүртгэлд бүртгэсүгэй

5. 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 16 тоот актаар хүлээн авсан Камержуулалт ажлыг 10060000 төгрөгийн хөрөнгийг Засаг даргын Тамгын газар, 4940000 /Дөрвөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга/ төгрөгийн хөрөнгийг сургуулийн хөрөнгийн бүртгэлд бүртгэсүгэй

6. Хөрөнгийг данс бүртгэлдээ зохих журам зааврын дагуу авч, эзэмшигчийг тогтоон хариуцуулж ажиллахыг байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Б. ГАНТУЛГА

